



**ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 08 сарын 31 өдөр

Дугаар A/494

Эрдэнэт


Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1/е/, 29.2, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Татварын хэлтсийн албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр Дархан-Уул аймагт 2 хоног зохион байгуулагдах төвийн бүсийн татварын албаны ажилтнуудад зориулсан “Татвар хураалтын ажлыг боловсронгуй болгох нь” сэдэвт туршлага солилцох уулзалт-зөвлөгөөнд оролцох ажлын зарим зардлыг хавсралтаар баталсугай.


2.Тус зөвлөгөөнд шаардагдах 4498000 /Дөрвөн сая дөрвөн зуун ерэн найман мянган/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ

Аймгийн Засаг даргын 2017 оны  
08 дугаар сарын 31-ны өдрийн  
499 дугаар захирамжийн хавсралт



**“ТАТВАР ХУРААЛТЫН АЖЛЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ”  
СЭДЭВТ ТУРШЛАГА СОЛИЛЦОХ УУЛЗАЛТ ЗӨВЛӨГӨӨНД ОРОЛЦОХОД  
ШААРДЛАГАТАЙ ЗАРДЛЫН ТООЦОО**

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Тоо хэмжээ	Нийт үнэ
1	Тээврийн хөлс	Литр	1750	800	1 400 000
2	Гарын авлага хэвлүүлэх	Ширхэг	3900	350	1 365 000
3	Анонс хэвлүүлэх	Метр/кв	9000	12	108 000
4	Энгэрийн тэмдэг	Ширхэг	2500	50	125 000
5	Байрлах зардал /2 хоног/	Хүн хоног	30000	50	1 500 000
<b>Нийт дүн</b>					<b>4 498 000</b>